

ТӨРИЙН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

1. Төрийн албаны сонгон шалгаруулалт

Сонгон шалгаруулалтад бүртгүүлэх иргэнд тавигдах болзол:

- Монгол Улсын иргэн байх;
- Дээд боловсролтой байх;
- Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх;
- Сэтгэцийн өвчин эмгэггүй байх;
- Цэргийн алба хаасан байх;
- Тухайн орон нутагт төрийн жинхэнэ алба хаах хүсэлтэй байх;
- Тэтгэвэр тогтоолгох насанд хүрээгүй байх;
- Төрийн албанд эргэж орох эрхгүйгээр хугацаа зааж халсан бол уг хугацаа дууссан байх;
- Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэж шүүхээр нийтийн албанд ажиллах эрх хасах ял шийтгүүлсэн бол уг хугацаа дууссан байх.

Сонгон шалгаруулалтад бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичиг:

- Шалгалтад бүртгүүлэхээр гаргасан хүсэлт; (хүсэлтийг цахимаар бөглөнө.)
- Төрийн албан хаагчийн анкет; (анкетыг цахимаар бөглөнө.)
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг;
- Иргэний үнэмлэх;
- “4 x 6”-гийн хэмжээний цээж зураг;
- Цэргийн алба хаасан тухай баримт бичиг;
- Хөгжлийн бэрхшээлтэй бол энэ тухай нотолсон баримт.

Баримт бичгийг дутуу бүрдүүлсэн иргэн бүртгэлд хамрагдах боломжгүй.

2. Төрийн одон медаль

- Одон, медалиар шагнуулахаар нэр дэвшигчийн анкет
- Ажил байдлын тодорхойлолт
- Хурлын албан тэмдэглэл, шийдвэрийн хамт сум, аймгийн Засаг даргад уламжилна.
- Аймгийн Засаг дарга бичиг баримтын бүрдэлт, шагнуулах үндэслэл, тодорхойлолтыг хянан үзэж, шагналд уламжлах эсэхийг нарийвчлан шүүж, холбогдох яам, харьяа дээд газар, төрийн бус байгууллага, улс төрийн нам, мэргэжлийн эвсэл, холбоодын орон нутгийн ба төв байгууллагын хамтын удирдлагын дүгнэлт, саналыг бичгээр авч хавсарган явуулна.

3. Ашигт малтмал хайх, ашиглах

- Хайгуулын тусгай зөвшөөрлийн /га/ тутамд:
 - Эхний жил-200 төгрөг
 - 2 дахь жил-400 төгрөг
 - 3 дахь жил-600 төгрөг
 - 4-5 дахь жил-2000 төгрөг

Тушаах банк, данс: /Төрийн сан банк/

Дархан сум-100190100941

Хонгор сум-100190200941
Орхон сум-100190300941
Шарын гол сум-100190400941

- Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр /га/ тутамд:
0-20 га-5000 төгрөг
30 га хүртэл-8000 төгрөг
50 га хүртэл-10000 төгрөг
100 га хүртэл-15000 төгрөг
200 га-аас дээш-20000 төгрөг

Тушаах банк, данс: /Төрийн сан банк/

Дархан сум-100190100941
Хонгор сум-100190200941
Орхон сум-100190300941
Шарын гол сум-100190400941

- Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөх

Тушаах банк, данс: /Төрийн сан банк/

Дархан сум-100190100948
Хонгор сум-100190200948
Орхон сум-100190300948
Шарын гол сум-100190400948

4. Сүм хийдийн зөвшөөрөл

Сүм хийд байгуулах, үйл ажиллагааг явуулах зөвшөөрөл авахыг хүссэн иргэд аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:

- Тухайн шашны байгууллага байгуулах үндэслэл, хэрэгцээ шаардлага, үйл ажиллагааны онцлогийг тусгасан өргөдөл;
- төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан шаардлагыг бүрэн хангасан дүрэм;
- шашны байгууллага байгуулахаар санал нэгдсэн хүмүүсийн хурлын шийдвэр, дэлгэрэнгүй тэмдэглэл;
- шашны байгууллага байгуулахыг анх санаачлагчид, удирдах зөвлөл, үүсгэн байгуулагчид, ажиллагсдын товч бүртгэл /ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, регистрийн дугаар, боловсрол, мэргэжил, эрхэлж байгаа ажил, төгссөн сургууль, хэрэв суралцаж буй бол тухайн сургуулийн нэр, гэрийн хаяг, утас цахим шуудангийн хаяг, зөвшөөрснийг гэрчлэх гарын үсэг/;
- үйл ажиллагаа явуулах байршил, газар эзэмших гэрчилгээ, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ, хэрэв түрээсийн байранд ажиллаж байгаа бол түрээслэгчтэй хийсэн гэрээ, нотариатаар баталгаажуулсан хуулбарын хамт;
- шашны байгууллагаас тухайн шашны зан үйлийг явуулахад шаардагдах ном, судар, бусад шаардлагатай хэрэгслийн жагсаалт, түүхийн үнэт өв эдлэлийн жагсаалт, хөрөнгө санхүүгийн хэмжээ, эх үүсвэр, тусламж, хандив, зардлын тооцоо;

- шашны байгууллагын зорилго, шүтэж итгэдэг номлолын үндсэн үзэл санаа, үйл ажиллагааны зарчим, хамрах хүрээ, төрөл хэлбэр, гадаад харилцааны талаарх танилцуулга;
- шашны байгууллагаас шүтэн бишрэгчид, итгэгчдийн дунд зохиох ажлын гол агуулга, чиглэл;
- тухайн шашны байгууллага байгуулахыг дэмжсэн баг, сумын Засаг даргын албан бичиг;
- шашны байгууллагын номлол, сургаал айлдагч нь гадаадын иргэн бол тохирсон ангиллын оршин суух "SH", зөвшөөрөл бүхий гадаадын иргэн, түүний бүртгэл, фото зураг, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх байгууллагын болон цагдаагийн байгууллагын тодорхойлолт, ажиллаж байгаа газрын тодорхойлолт;
- нэр давхацсан эсэхийг тодруулсан Улсын бүртгэлийн байгууллагын лавлагаа;
- шинээр зөвшөөрөл авахад холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг авна.

**Үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг сунгуулахад
бүрдүүлэх баримт бичиг**

Шашны байгууллагын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг сунгахад дараах баримт бичгийг бүрдүүлж, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын халтэст ирүүлнэ. Үүнд:

- тухайн шашны байгууллагаас үйл ажиллагааныхаа хугацааг сунгуулах хүсэлтээ илэрхийлсэн албан бичиг;
- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- тухайн хугацаанд тус шашны байгууллагаас хийсэн ажлын товч тайлан;
- зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргахаас өмнөх жилийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан;
- хүсэлт ирүүлсэн шашны байгууллагын Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн болон байгууллагын дүрэмд өөрчлөлт оруулсан эсэх, хэрэв өөрчлөлт орсон бол уг өөрчлөлтийн талаарх мэдээлэл;
- тухайн шашны байгууллагад ажиллагсдын тоо;
- тухайн шашны байгууллагын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг сунгуулахыг дэмжсэн баг, сумын Засаг даргын албан бичиг.